

□

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 26

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ТООЛЛОГЫН КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 9<sup>1.3</sup> дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Батжаргалын Батзоригийн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх эсэх асуудлаар нууц санал хураалтыг зохион байгуулж, дүнг танилцуулах үүрэг бүхий тооллогын комиссыг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Д.Лүндээжанцан, Г.Мөнхцэцэг, Д.Тэрбишдагва нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. Нууц санал хураалт явуулах журмыг тогтоож, санал хураалтыг зохион байгуулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулахыг тооллогын комисст даалгасугай.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР